

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй хөрөнгө оруулалтын ажлууд батлагдсаар байна.



2017.04.06-ны өдөр

Чойбалсан хот

А.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг батлах асуудал хэвээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:


- Эрх шилжиж ирсэн Чойбалсан сумын цэцэрлэгийн халаалтын тогооны засвар /36.0 сая/, Баянтүмэн сумын сургуулийн барилгын засвар /115.8 сая/, Хэрлэн сумын 12-р сургуулийн барилгын засвар /64.0 сая/-ын ажлууд нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Тухайлбал,
- "Тусгаар тогтнолын талбай"-д Маршал Х.Чойбалсангийн хөшөө байгуулахад дэмжлэг - 30.0 сая төгрөг
- “Мэдээлэлжсэн, нээлттэй хот” төсөл /google map дахь аймгийн зураглал мэдээллийг хөгжүүлэх/, - 36.9 сая төгрөг
- Сумын төвийн гэрэлтүүлгийг шинэчлэх /Цагаан-Овоо сум/ - 30.0 сая төгрөг
- Төмөр замын Баянтүмэн тасгийн Хэрлэн өртөөний 0.4 КВ-ын ЦДАШ-ын засвар /Чойбалсан сум/ - 12.0 сая төгрөг
- Сургуулийн барилгын засвар /Чулуунхороот сум/ - 20.0 сая төгрөг
- Аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн байрны засвар, тохижилт – 9.2 сая төгрөг
- Орон нутгийн судлах музейн барилгын өргөтгөл, гадна талбайн засвар, тохижилт /Гурванзагал сум/ - 70.0 сая төгрөг
- Сумын эрүүл мэндийн төвд дуудлагын авто машин /Хөлөнбуйр сум/- 30.0 сая төгрөг
- Аймгийн Хөгжимт драмын театрт авто машин авах - 20.0 сая төгрөг
- Аймгийн төв номын санд эрдэм шинжилгээний танхим байгуулах – 10.0 сая төгрөг
- Аймгийн төв музейд галын багаж хэрэгсэл худалдан авах /Хэрлэн сум/ - 5.3 сая төгрөг

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигт тусгагдаагүй батлагдсан төсөл, арга хэмжүүнүүд 2015 онд нийт төсөл, арга хэмжээний 43.0 хувийг эзэлж байсан бол 2016 онд 34.0 хувийг эзлэж байна.

Дүрслэл №1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, бусад бодлогын баримт бичигт тусгагдаагүй ТАХ-нүүд /эзлэх хувь 2015-2016/



А.2. Хэрэгцээ, шаардлага, төсвийг оновчтой тодорхойлоогүйгээс зарим хэрэгцээтэй төсөл, арга хэмжээ хасагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнүүд нь 100.0 хувь нийгмийн салбарт буюу сургууль, цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээнүүд төлөвлөгдсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Улсын төсөвт байгууллагын барилга байгууламж засварлах, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн нийт 73.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн. Тухайлбал,
- БОЭТ-ийн 50 ортой төрөх эмнэлэгт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авахад 20.0 сая,
- БОЭТ-ийн мэс заслын тасагт нөхөн сэргээх эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж авахад 20.0 сая,
- БОЭТ-ийн дотрын тасагт эмчилгээний өрөө тохижуулахад 15.0 сая,
- Аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн байрны засвар, тохижилт 9.2 сая,
- Аймгийн Татварын хэлтсийн гадна фасадын засвар 9.7 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталж, хэрэгжүүлжээ.
- Хэрлэн сумын 4-р багийн шинэ цэцэрлэгийн дэд бүтэц татах 200.0 сая, Халхгол сумын Ялалт багийн цагдаагийн хэсгийн байр барих 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн ч, төсөвт өртгөөс хэтэрсэн, зураг төсөвгүй гэх үндэслэлээр аймгийн ИТХ-ын тодотголоор хасагдсан байна.

А.4. ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй хөрөнгө оруулалтын ажлууд батлагдсаар байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Эрх шилжиж ирсэн шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 /Хэрлэн сумын 12 болон Баянтүмэн сумын сургуулийн барилгын засвар, Чойбалсан сумын цэцэрлэгийн халаалтын тогооны барилгын засвар/ төсөл, арга хэмжээ нь зураг төсөвгүй батлагдсан учраас, батлагдсанаас нь хойш зураг, төсөв хийлгэх ажлыг зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймгийн хэмжээнд 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр санхүүжигдэх нийт 32 төсөл, арга хэмжээ төлөвлөсний зураг төсөв хийлгэх шаардлагагүй 16, зураг төсөв хийлгэх шаардлагатай 16 төсөл, арга хэмжээ байсан. 2016 онд хэрэгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 төсөл, арга хэмжээ нь нь зураг төсөвгүй батлагдаж, батлагдсанаас хойш зураг төсөв хийлгэх тендерийн ажил зохион байгуулсан байна. Өмнөх 2015 онд зураг, төсөв хийгдээгүй 3 төсөл, арга хэмжээг баталсан зөрчил 2016 онд давтагдаж байна.
- Аймгийн 2016 оны төсвийн төсөлд нийт 220.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байгаа тул хасах санал өгсөн ч байна.

Дүрслэл №2. Зураг төсөвгүй батлагдсан төсөл, арга хэмжээ
/тоогоор 2015-2016/



А.6. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, ангилал, нэрийг зөрүүтэй баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, ангилал, нэрийг зөрүүтэй баталж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, тайлан, мэдээ зөрүүтэй илэрхийлэгдэх шалтгааныг дагуулж байна. Тухайлбал:
- Чойбалсан сумын цэцэрлэгийн халаалтын тогооны засвар нэрээр хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын XII.1.2.2-т батлагдсан ч, “Цэцэрлэгийн халаалтын тогоо”-ны барилгын засвар, Хэрлэн сумын 12-р сургуулийн барилгын засвар нэрээр хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын XII.1.2.2-т батлагдсан ч, “12-р сургуулийн барилгын” дээврийн засварын ажил гэж өөрчлөгдөн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга, хэмжээнүүд нь нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд зөрүүтэй тусгагдсан ажлууд байхгүй байна.

II. Бүлэг: Тендерт оролцогч аж ахуй нэгжүүд өмнөх оноос буурсан байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Улсын төсвийн санхүүжилтээр 3 их засварын ажлыг журмын дагуу үнэлгээний хороог байгуулж НТШ-аар 1, ХА-аар 2 тендерийг www.e-procurement.gov.mn, www.e-procurement.dd.gov.mn, цахим сайтад зарласан ч ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн ...” гэсэн заалтыг огт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 22 төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулахдаа 1 буюу 4.5 хувийг НТШ, 16 буюу 72.7 хувийг харьцуулалтын, 3 буюу 13.6 хувийг шууд гэрээ байгуулах, 1 буюу 4.5 хувийг зөвлөхөөс бусад үйлчилгээний аргаар тус тус шалгаруулжээ.
- Аймгийн Засаг даргын 2016 оны А/62 тоот захирамжаар ХХААГ-т эрх шилжүүлсэн малжуулах төсөл хэрэгжүүлэх /Булган сум/ 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг зохион байгуулахдаа цахим сайтад тендерийн урилга нийтлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.5 болон 52.1.12 дахь заалтууд, үнэлгээний хорооны даргаас бусад гишүүд ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаагүй нь уг хуулийн 47.6 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Энэ хуулийн 52.1.12-т дурдсан вэб хуудсанд тендерийн урилгыг заран мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар

худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилголтой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох

Б.2 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.3, 11.1.4, 15.3.4, 16.1.2, 34.2 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Аймгийн Хөгжимт драмын театрт авто машин авах /Хэрлэн сум/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгэж байгаагүй “Ган хийцэт харш” ХХК-тай гэрээ байгуулсан нь ТБОНХБАХАТ хуулийн 15.3.4, 16.1.2, 34.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.


Тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаархи мэдээлэл

Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт

Энэ хуулийн 34.1-д заасан нөхцлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээрийн үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

- 
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор замын цагдаа нарыг багаж хэрэгслэлээр хангах /Цагдаагийн газар/ тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод тухайн бэлэн бус торгуулийн төхөөрөмжийг нэр заан /M3 mobile/ тодорхойлсон нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.3. "барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл ... тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй;", мөн 11.1.4-т "энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүрслэл №4. Худалдан авах ажиллагааны харьцуулалтын судалгаа.



III Бүлэг: Төрийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээ дутуу буюу эхлээгүй байна.

В.1 Ашиглагч байгууллагад эрх нь шилжсэн зарим орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 3 төсөл, өмнөх оноос шилжиж ирсэн 2 арга хэмжээнээс төлөвлөлтийн дагуу 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ /аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга/ дуусаагүй байна.
- Бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас 1 ажил буюу “Сүхжин” ХХК-ийн гүйцэтгэсэн Чойбалсан сумын цэцэрлэгийн халаалтын тогооны засварын ажлын хугацаа 9 хоногоор хэтэрсэнийг шалгахад цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- "Тусгаар тогтнолын талбай"-д Маршал Х.Чойбалсангийн хөшөө байгуулахад дэмжлэг, аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн байрны засвар, тохижилт, Спорт төвийн засвар, тохижилт, Цагдаагийн газрын барилгын фасадын засварт дэмжлэг үзүүлэх зэрэг эрх нь тухайн сум, байгууллагад шилжсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээний нөхцлүүд тодорхой бус, нөхцлүүдийг хавсаргаагүй зэрэг зөрчил байна.
- Бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас 4 ажлыг гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан хугацаанаас 1-8 хоногоор хэтрүүлэн ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.
- Гүйцэтгэгчээс шалтгаалж хугацаа хэтэрсэн дараах 4 ажлуудад нийт 171.0 мянган төгрөгийн алдангийг суутган тооцсон байна. Үүнд:
 - “Талын сүлд” ХХК-ийн гүйцэтгэсэн Монгол дайчдын хөшөөний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил 1 хоногоор хугацаа хэтэрсэнд 18.1 мянган төгрөгийн алданги,
 - “Бүжнар” ХХК-ийн гүйцэтгэсэн Чулуунхороот сумын сургуулийн барилгын засвар 2 хоногоор хугацаа хэтэрсэнд 17.3 мянган төгрөгийн алданги,
 - “Сүвэн-Уул” ХХК-ийн гүйцэтгэсэн БОЭТ-ийн 50 ортой төрөх эмнэлэгт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажил 8 хоногоор хугацаа хэтэрсэнд 75.7 мянган төгрөгийн алданги,
 - “Сүвэн-Уул” ХХК-ийн гүйцэтгэсэн БОЭТ-ийн дотрын тасагт эмчилгээний өрөө тохижуулах ажил 8 хоногоор хугацаа хэтэрсэнд 59.9 мянган төгрөгийн алданги.

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Хүснэгт №5. Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл (сая.төг, хувиар)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2016 онд санхүүжих дүн	2016 онд олгосон санхүүжилт	Нийт олгосон санхүүжилт	Гүйцэтгэл хувиар
1	Аймгийн Засаг даргын тамгын газрын барилга /Дорнод – Хэрлэн сум/ (шилжих 2011-2017)	6541.0	6194.1	1498.5	1450.0	4383.11	65
2	Сургуулийн барилгын засвар /Дорнод, Баянтүмэн сум/	115.8	108.4	115.8	108.4	108.4	100
3	Сургуулийн барилгын засвар /Дорнод, Хэрлэн сум, 12-р сургууль/	64.0	53.0	64.0	53.0	53.0	100
4	Цэцэрлэгийн халаалтын тогооны засвар /Дорнод, Чойбалсан сум/	36.0	36.0	36.0	36.0	36.0	100
5	БОЭТ-ийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан/ (шилжих 2015-2016)	309.8	278.8	164.9	133.9	278.8	100

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.
- Үүнээс 33.3 хувь буюу 465.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ өмнөх оноос шилжин ирж, 66.7 хувь буюу 932.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

Дүрслэл №6. Батлагдсан төсөл, арга хэмжээний зориулалт.




- Нийт төсөл, арга хэмжээг хэрэгжсэн байдлаар авч үзвэл 13 буюу 224.2 сая төгрөгийн ажил өмнөх онд хэрэгжиж, 2016 онд санхүүжилтийн үлдэгдлийг олгосон, мөн хөрөнгө оруулалтаас 4 буюу 226.0 сая төгрөгийн ажил дутуу буюу хэрэгжээгүй байна.
- Өмнөх оноос шилжиж ирсэн болон шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтаар ангилбал: 367.6 сая төгрөгийн барилга, байгууламж, дэд бүтэц, 120.0 сая төгрөгийн их засвар, 308.3 сая төгрөгийн зам, 151.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж тус тус эзлэж байна.

Дүрслэл №7. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зориулалт.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

■ Барилга, дэд бүтэц ■ Тоног төхөөрөмж ■ Их засвар ■ Зам





В.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний 511.3 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын тодотголоор хасаж дутуу санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 3, өмнөх оноос шилжиж ирсэн 2, нийт 5 төсөл арга хэмжээнээс төлөвлөлтийн дагуу 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ дутуу буюу улсын комисс хүлээн аваагүй байна. Үүнд:
- Нийт 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын ажилд 2016 онд 1.4 тэрбум төгрөг батлагдан гүйцэтгэл 65.0 хувьтай, санхүүжилтээс шалтгаалж гэрээг сунгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймагт 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 32, өмнөх оноос шилжиж ирсэн 3, нийт 35 төсөл, арга хэмжээнээс 31 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 4 төсөл арга хэмжээ дутуу буюу эхлээгүй байна. Үүнд:
- Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэгийн барилгын засварын ажил нь 2016 оны 9, 12 дугаар саруудад аймгийн төсвийн тодотголоор нэмэгдэж батлагдсан бөгөөд дээврийн засварын ажлыг хүйтний улиралд гүйцэтгэх боломжгүй болсон учир үлдсэн ажлыг 2017 оны хавар гүйцэтгэхээр гэрээнд өөрчлөлт оруулсан байна.
- Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн сантехник, цахилгаан монтаж засварын ажил нь 2016 оны 12 дугаар сарын аймгийн төсвийн тодотголоор нэмж батлагдан оны төсвийн жилд хэрэгжүүлээгүй гэрээг 2017 онд байгуулсан байна.
- Хэрлэн сумын 4-р багт цэцэрлэгийн шинэ барилгын дэд бүтэц татахаар төлөвлөгдсөн 200.0 сая төгрөгийг төсөвт өртөг уг ажлыг хийхэд хүрэлцэхгүй гэж үзэн хассан байна.
- Халхгол сумын Ялалт багийн цагдаагийн хэсгийн байрыг барихаар төлөвлөгдсөн 20.0 сая төгрөгийг төсөвт өртөг уг ажлыг хийхэд хүрэлцэхгүй гэж үзэн хассан байна.

- 
- Мөн төсвийн орлого буурсантай холбоотой нийт хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 511.3 сая төгрөгийг 2016 оны төсөвт тодотгол хийж 2017 оны орон нутгийн төсөвт шилжүүлэхээр болсон байна.
 - Хэрлэн сумын 6, 10-р багийн ажлын алба, агентлаг, өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт 450.0 сая төгрөг,
 - БОЭТ-ийн мэс заслын тасагт нөхөн сэргээх эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн үлдэгдэл санхүүжилт 10.0 сая төгрөг,
 - Булган суманд малжуулах төсөл хэрэгжүүлэхэд 40.0 сая төгрөг,
 - Төмөр замын Баянтүмэн тасгийн Хэрлэн өртөөний 0.4 КВ-ын ЦДАШ-ын засварын ажлын санхүүжилт 11.3 сая төгрөг.



В.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээ үр ашиггүй, шаардлага хангахгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймагт 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 3 төсөл, өмнөх оноос шилжиж ирсэн 2 арга хэмжээнээс төлөвлөлтийн дагуу 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ дутуу буюу улсын комисс хүлээн аваагүй байна. Үүнд:
- Нийт 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын ажилд 2016 онд 1.4 тэрбум төгрөг батлагдан ГХБХБГ-аас хяналтыг хийж ажилласан байна.
- Чойбалсан сумын Цэцэрлэгийн халаалтын тогооны барилгын засвар, Баянтүмэн болон Хэрлэн сумын 12 дугаар сургуулиудын засварын ажил дуусч ашиглалтад оруулсан.
- БОЭТ-ийн барилгын 309.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлыг “Дорнын пирамид” ХХК чанаргүй гүйцэтгэсэн.

БОЭТ-ийн засварын ажлын бодит байдал



- 
- 2015 онд Чулуунхороот сумын сургуулийн барилгын 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил дууссан боловч улсын комисс гүйцэтгэлийг шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр хүлээж аваагүй.
 - 2015 онд Хэрлэн сумын 2 дугаар багийн 878.6 сая төгрөгийн өртөгтэй Спорт заалны барилгын ажил дуусч ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч одоог хүртэл ашиглалтын зардал шийдэгдээгүйгээс үйл ажиллагаа явагдаагүй, ашиглаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Чулуунхороот сумын сургуулийн барилгын засварын ажлыг үзэхэд спорт заал, шатны таазны замаск хууларч унасан байдалтай байна.




Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

- “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 20 зөвлөмж, 9 албан шаардлага, 1 төлбөрийн акт тавьсан болно.
- Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 6/1041 тоот албан бичгээр дээрх аудитын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна гэсэн тоот ирүүлсэн.
- Хэрэгжээгүй зөвлөмж 3 байна. Үүнд:
- Зураг төсөв, магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг батлахгүй байх.
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хуваарилахдаа орон нутгийн эрх ашигт нийцүүлэн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодлогын шинж чанартай салбаруудад хуваарилалт хийх.
- Улсын комисс хүлээж аваагүй төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах.
- Мөн Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэсэн заалттай нийцээгүй урсгал зардалд 19.0 сая төгрөгийн зардлыг гаргасан тул аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дансанд буцааж төвлөрүүлэх гэсэн төлбөрийн актыг одоог хүртэл барагдуулаагүй байна. Аудитын явцад барагдуулах хугацаатай үүрэг өглөө.

Ерөнхий дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд гарч байгаа зөрчил, дутагдал жил бүр давтагдаж, ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй хөрөнгө оруулалтын ажлууд батлагдаж байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021/, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилтод тусгагдаагүй ажлуудыг батлах асуудал хэвээр байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ, зураг төсөв, хуулийн шаардлага хангаагүй ажлуудыг баталж байна. Хэрлэн сумын 4-р багийн шинэ цэцэрлэгийн дэд бүтэц татах, Халхгол сумын Ялалт багийн цагдаагийн хэсгийн байр барих ажлууд хасагдсан байна. Энэ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудыг урьдчилсан тооцоо судалгаа, техник, эдийн засгийн үр ашиг, зураг төсвийг хийлгүйгээр төлөвлөж байгаа нь аймгийн ИТХ-аар дэмжигдэхгүй байх, хэрэгцээтэй ажлууд хөрөнгө оруулалтын жагсаалтаас хасагдах, нийгэмд хэрэгцээтэй төсөл, арга хэмжээнүүд хэрэгжихгүй байх эрсдэлүүд үүсэж байна.
- ХХААГ нь малжуулах төслийн тендерийг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд нь АЗ гэрчилгээгүй, техникийн тодорхойлолтыг зах зээлийн ханшнаас хэт өндөр үнээр боловсруулж батлуулсан байна.

- 
- Аймгийн Хөгжимт драмын театрт авто машин авах /Хэрлэн сум/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд өмнө нь ижил төстэй ажил гүйцэтгэж байгаагүй “Ган хийцэт харш” ХХК-тай гэрээ байгуулсан байна.
 - ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.3, 11.1.4, 15.3.4, 16.1.2, 21.1, 34.2 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
 - Төрийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээ дутуу буюу эхлээгүй байна.
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээ үр ашиггүй, шаардлага хангахгүй байна.
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хийгдсэн 1 төсөл, арга хэмжээг одоо болтол улсын комисс хүлээж аваагүй байна.
 - Аудитаар нийт 1.3 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.2 тэрбум төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 8 зөвлөмж өгч ажиллалаа.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

- **Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Энх-Отгон, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Болормаа, ГХБХБГ-ын дарга Д.Дамдинбазар нарт:**
- Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөж, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг батлахдаа хуулийн шаардлагад нийцүүлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг /үүнд: аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021/, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт/-т үндэслэж, тооцоо судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвтэй эсэхийг хянан үзэж, баталж байх.
- Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлж, хөрөнгө оруулалтын ажлууд батлагдахаас өмнө зураг төсөв, ТЭЗҮ-г хуулийн шаардлагад нийцүүлэн урьдчилан бэлтгэж ИТХ-д танилцуулж байх.
- Улсын комисс хүлээж аваагүй 1 төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах.
- Ашиглагдахгүй байгаа Хэрлэн сумын 2 дугаар багийн Спорт заалыг ашиглалтад оруулж үр ашгийг дээшлүүлэх.
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч “Суурин тал”, “Дорнын пирамид”, “Бүжнар” ХХК-иудад хариуцлага тооцох.


■ Төсвийн тухай хуулийн 28-р зүйл: **Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт**

Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүйд:

- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.3, 11.1.4, 15.3.4, 16.1.2, 21.1, 34.2 дэх заалтуудыг мөрдөж ажиллах.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ц.Энхтүвшинд:

- ХХААГ-ын үнэлгээний хороонд АЗ гэрчилгээтэй албан хаагчдыг томилох, техникийн тодорхойлолтыг зах зээлийн ханшийн судалгаа мэдээллийг үндэслэн боловсруулж, батлуулж байхад анхаарч ажиллах.
- Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2017 оны 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх.



***АНХААРАЛ ТАВЬСАН ТА
БҮХЭНД БАЯРЛАЛАА***